

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЭМНДШ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ц.УРАНЧИМЭГ ТАНАА

2021.02.25 № 07/510
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>152,920,615.01</u>	<u>391,000,546.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	2,834,100.00	100,758,267.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,468,500.00	100,758,267.13
335	Бусад авлага	365,600.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	365,600.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	150,086,515.01	290,242,279.63
351	Түүхий эд материал	113,203,396.54	240,327,025.75
35130	Эм боох материал	111,486,417.54	240,187,025.75
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,716,979.00	140,000.00
354	Хангамжийн материал	36,883,118.47	49,915,253.88
35410	Бичиг хэргийн материал	5,128,382.00	3,443,250.00
35420	Аж ахуйн материал	12,800,505.00	12,640,109.51
35440	Түлш, шатах тослох материал	2,201,730.87	4,731,430.87
35460	Хүнсний материал	9,794,298.00	19,733,944.50
35470	Бусад хангамжийн материал	6,958,202.60	9,366,519.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,875,183,895.80</u>	<u>3,884,214,341.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,875,183,895.80	3,884,214,181.03
392	Биет хөрөнгө	3,674,248,094.20	3,677,757,289.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,207,087,798.60	3,207,087,798.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(157,086,503.22)	(288,075,493.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	145,609,300.00	136,109,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(87,884,440.38)	(97,676,940.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,521,499,667.06	1,620,645,270.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,113,026,749.44)	(1,059,274,468.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	417,396,389.20	415,809,245.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(259,347,367.02)	(256,867,422.17)
393	Биет бус хөрөнгө	200,935,801.60	206,457,051.60
39301	Програм хангамж	45,529,538.00	53,004,538.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(22,286,216.40)	(24,239,966.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,692,480.00	177,692,480.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,028,104,510.81</u>	<u>4,275,214,887.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>26,069,453.12</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,069,453.12	-
413	Өглөг	26,069,453.12	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	23,931,953.12	-
4136	Бусад өглөг	2,137,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,137,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,002,035,057.69</u>	<u>4,275,214,887.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,002,035,057.69	4,275,214,887.79

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,470,206,581.32	2,470,206,581.32
51101	Өмч: - төрийн	2,470,206,581.32	2,470,206,581.32
512	Хуримтлагдсан үр дүн	(868,178,606.35)	(585,498,776.25)
51210	Өмнөх үеийн үр дүн	(868,178,606.35)	(858,678,606.35)
51220	Тайлант үеийн үр дүн	-	273,179,830.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,400,007,082.72	2,390,507,082.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,028,104,510.81</u>	<u>4,275,214,887.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,657,651,875.00	4,717,155,815.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	468,259,540.00	1,210,152,134.00
120	Нийтлэг татварын бус орлого	468,259,540.00	1,210,152,134.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	380,379,540.00	1,210,152,134.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	367,895,036.17	953,219,429.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,484,503.83	65,634,285.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,880,000.00	191,298,420.00
120009	Бусад орлого		-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,189,392,335.00	3,507,003,681.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	145,025,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	145,025,400.00	-
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	187,515,410.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	187,515,410.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,856,851,525.00	3,507,003,681.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,856,851,525.00	3,507,003,681.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,847,161,353.72	4,443,975,984.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,847,161,353.72	4,443,975,984.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,792,773,116.00	4,367,149,609.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,026,978,960.02	2,467,025,155.10
210101	Үндсэн цалин	2,026,978,960.02	2,423,375,560.10
210102	Нэмэгдэл	-	3,079,595.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-
210104	Урамшуулал		40,570,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	277,624,766.75	334,566,953.40
210201	Тэтгэврийн даатгал	277,624,766.75	216,276,576.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	24,617,495.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	42,025,113.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,559,969.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	47,087,800.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,308,065.13	125,771,610.80
210301	Гэрэл, цахилгаан	53,278,163.50	58,517,072.00
210302	Түлш, халаалт	27,956,558.63	29,902,551.60
210303	Цэвэр, бохир ус	33,073,343.00	37,351,987.20
2104	Хангамж, бараа материалын зардал	107,268,609.09	99,838,996.94
210401	Бичиг хэрэг	24,317,762.00	24,968,429.90
210402	Тээвэр шатахуун	8,978,082.43	2,384,920.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,600,257.66	8,888,171.55
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,346,313.00	49,509,222.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,026,194.00	14,088,252.50
2105	Нормативт зардал	775,289,161.66	747,040,143.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	544,134,876.52	538,733,735.79
210502	Хоол, хүнс	216,814,050.14	196,712,357.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,340,235.00	11,594,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,276,940.00	192,589,475.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,861,100.00	9,086,060.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,692,510.00	925,000.00
210604	Урсгал засвар	81,723,330.00	182,578,415.00
2107	Томилот, зочны зардал	4,029,400.00	1,115,600.00
210702	Дотоод албан томилот	4,029,400.00	1,115,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,937,180.00	39,366,543.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	21,122,383.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,504.00	228,096.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,176.00	413,976.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	59,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,684,700.00
210807	Газрын төлбөр	-	2,788,388.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,209,500.00	5,069,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	393,060,033.35	359,835,131.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,633,064.36	43,682,497.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,491.00	2,147,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	342,309,477.99	314,004,984.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,082,567.00	76,826,375.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,082,567.00	76,826,375.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,905,900.00	61,445,675.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,176,667.00	15,180,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,305,670.72	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,305,670.72	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	251,355,907.90	273,179,830.10
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(189,509,478.72)	273,179,830.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,540,311,580.00	4,529,643,477.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	380,048,540.00	1,022,639,796.00
120	Нийтлэг татварын бус орлого	380,048,540.00	1,022,639,796.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	380,048,540.00	1,018,736,114.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	369,495,036.17	953,101,829.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,553,503.83	65,634,285.00
120009	Бусад орлого		3,903,682.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,160,263,040.00	3,507,003,681.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	145,025,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	145,025,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,386,115.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,740,105.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	147,646,010.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,856,851,525.00	3,507,003,681.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,856,851,525.00	3,507,003,681.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,486,124,512.00	4,356,472,347.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,486,124,512.00	4,356,472,347.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,431,736,274.28	4,178,887,704.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,022,743,294.28	2,482,170,390.34
210101	Үндсэн цалин	1,145,859,794.28	1,949,437,927.22
210102	Нэмэгдэл	605,155,500.00	338,074,525.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	161,700,000.00	155,022,432.25
210104	Урамшуулал	110,028,000.00	39,635,505.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	252,031,386.20	334,264,808.28
210201	Тэтгэврийн даатгал	172,944,786.20	334,264,808.28
210202	Тэтгэмжийн даатгал	19,771,700.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,817,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	3,954,300.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	39,543,300.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,308,065.13	124,257,802.80
210301	Гэрэл, цахилгаан	53,278,163.50	58,517,072.00
210302	Түлш, халаалт	27,956,558.63	33,334,701.60
210303	Цэвэр, бохир ус	33,073,343.00	32,406,029.20
2104	Хангамж, бараа материалын зардал	104,107,712.66	101,762,458.05
210401	Бичиг хэрэг	15,298,814.00	21,099,507.00
210402	Тээвэр, шатахуун	11,002,400.00	7,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,558,657.66	8,888,171.55

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,909,081.00	53,355,070.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,338,760.00	11,419,709.00
2105	Нормативт зардал	801,674,304.01	850,267,303.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	566,040,688.01	627,388,923.00
210502	Хоол, хүнс	217,388,081.00	208,172,080.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,245,535.00	14,706,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,049,332.00	200,234,013.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,096,400.00	10,916,960.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,260,240.00	979,000.00
210604	Урсгал засвар	80,692,692.00	188,338,053.00
2107	Томилолт, зочны зардал	4,395,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	4,395,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,102,080.00	43,664,261.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,880,600.00	21,122,383.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	306,504.00	228,096.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,176.00	413,976.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	59,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,309,418.00
210807	Газрын төлбөр	-	2,788,388.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,493,800.00	8,742,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,325,100.00	41,516,668.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,325,100.00	38,795,154.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,721,514.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,388,237.72	177,584,642.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,082,567.00	76,826,375.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,905,900.00	61,991,837.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,176,667.00	14,834,538.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,305,670.72	100,758,267.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,305,670.72	100,758,267.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54,187,068.00	173,171,130.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,187,068.00	173,171,130.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,187,068.00	173,171,130.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,187,068.00	173,171,130.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,187,068.00	173,171,130.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(54,187,068.00)	(173,171,130.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.27	(678,669,127.63)	4,191,544,535.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.27	(678,669,127.63)	4,191,544,535.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	251,355,907.90	251,355,907.90
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.72	(868,178,606.35)	4,002,035,057.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,500,000.00	9,500,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.72	(858,678,606.35)	4,011,535,057.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(9,500,000.00)	-	(9,500,000.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	273,179,830.10	273,179,830.10
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,390,507,082.72	(585,498,776.25)	4,275,214,887.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,950,787,720.00	4,428,885,209.87	521,902,510.13	89.46
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,719,319,900.00	3,507,003,681.00	212,316,219.00	94.29
330002	Эрүүл мэнд даатгалын сангаас санхүүжих	3,719,319,900.00	3,507,003,681.00	212,316,219.00	94.29
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,231,467,820.00	1,018,736,114.00	212,731,706.00	82.73
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,157,820,820.00	953,101,829.00	204,718,991.00	82.32
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,647,000.00	65,634,285.00	8,012,715.00	89.12
65	Орон тооны мэдээлэл	149	149		100.00
650001	Удирдах ажилтан	1	1		100.00
650002	Гүйцэтгэх ажилтан	81	81		100.00
650003	Үйлчлэх ажилтан	56	56		100.00
650004	Гэрээт ажилтан	11	11		100.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус төвийн дарга Ц.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс ЭМНДШ суутган тооцоогүй, албан томилолтын олговрыг илүү олгосон, хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны материал, эмийн зарцуулалтад тавих хяналт сул талаар хоёр нөхөн төлбөрийн акт тогтоож, хоёр зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 1 дүгээр сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Хурц тооцолол аудит” ХХК-ийн аудитор Д.Лхамсүрэн, аудиторын туслах О.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Хурц тооцоолол аудит” ХХК-д 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн даатгалаар арьс харшлын өвчин, эмчилгээний гоо заслын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг. Эрүүл мэндийн болон Сангийн сайдын 2017 оны 7-р сарын 27-ны 264/А/293 тоот тушаал Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны 06 тоот албан даалгавар, төвийн захирлын 2019 оны 3 дугаар сарын 04-ний А/07 тоот тушаалаар төлбөртэй тусламж үйлчилгээний зохицуулалт хийгдэж ажилладаг болно.

Зорилго:

Олон улсын түвшинд хүрсэн Арьс, Харшил, Эмчилгээний гоо засал, арьсны мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлэх;

Зорилт:

Эмнэлгийн тусламж үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх зорилгоор эмчилгээ, оношилгооны шинэ технологийг нэвтрүүлэн, үйлчлүүлэгчдийн ая тух, чанар аюулгүй байдлыг хангаж ажиллахаар зорилт тавин ажиллахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хагас бие даасан байдал хэрэгжээд Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт орсон.

2. Мөн хуулийн 17.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр ТУЗ-аас томилсон байна.
3. Төсвөө төлөвлөж ТУЗ-аар батлуулж, орон тоо бүтцэд өөрчлөлт оруулах, шагнал урамшуулал олгох, цалингийн санг батлуулах, гүйцэтгэлд суурилж цалинжуулах, Төрийн албаны цалингийн шатлал баримтлахгүй байх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх эрх мэдэл ТУЗ-д шилжсэн.
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээг үйлдэлд суурилан өртөгжүүлж, ЭМД-ийн сангаас өртөгт суурилан гүйцэтгэлээрээ санхүүжилтээ авдаг болсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн яамнаас 2020 онд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалт орсон ч үнэлгээ сайн байна. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,847,161.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 76,943.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 247,110.4 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,834.1	100,758.3	97,924.2
Урьдчилгаа			
Бараа материал	145,071.7	284,713.4	139,641.7
Үндсэн хөрөнгө	3,880,198.7	3,889,743.2	9,544.4
Нийт хөрөнгө	4,028,104.5	4,275,214.9	247,110.4
Өр төлбөр			

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,002,035.1	4,275,214.9	273,179.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,028,104.5	4,275,214.9	247,110.4

Авлагын дансны үлдэгдэл 100,758.3 мянган төгрөг болж, 97,924.2 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 284,713.4 мянган төгрөг болж, 139,641.7 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж бодис нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулан 26 багцаар 147 нэр төрлийн эм, 31 нэр төрлийн түүхий эд, 71 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 16 нэр төрлийн ариутгалын бодис, 15 нэр төрлийн гоо сайхны эм, бүтээгдэхүүн, 248 нэр төрлийн лабораторийн урвалж бодис, 38 нэр төрлийн харшлын сорилын худалдан авалт хийхээр төлөвлөж, тендер зарласнаас 13 байгууллагын 11 нь шаардлагад нийцэж шалгарсан компаниудаас 98,604.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийснээс гадна ковид-19 цар тахалтай холбоотой 41,037.7 мянган төгрөгийн эм боох материал, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис хандиваар Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй ирсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд шаардлага хангахгүй, ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,889,743.2 мянган төгрөг болж, 9,544.4 мянган төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данснаас шаардлага хангахгүй, ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,002,035.1 мянган төгрөг болж, тайлант үеийн үр дүн 273,179.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 999,778.2 мянган төгрөгөөр буюу 27 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан болон үндсэн үйл ажиллагааны орлого байна. Эрүүл мэндийн яамнаас компьютерийн томограф, дижитал рентген аппарат, зөөврийн эхо аппарат, эм, вакцин, нэг удаагийн хамгаалах хэрэгслүүдийг ковид-19 цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй хуваарилсанаас мөн өөрийн орлого болох амбулаториос хийгддэг үйлчлүүлэгчдийн төлсөн болон резидент сургалтын төлбөр зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 537,088.9 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,949,469.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,001,318.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 4,950,787.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нэмэгдсэн шалтгаан нь тус төв хагас бие даасан байдалд шилжсэнтэй холбоотой гүйцэтгэлээр санхүүжилт авах

болсон. Мөн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 28 дугаар тогтоолоор тусламж үйлчилгээний өртгийн жинг баталсанаар өртөг 45-65 болж өссөнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн 3,719,319.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын газраас, 1,231,467.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,018,736.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3,507,003.7 мянган төгрөг нийт 4,525,739.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 4,424,981.5 мянган төгрөгийг зарцуулж, 100,758.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Харин 2020 оны орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нь Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийн тоог 2019 онтой харьцуулахад Ковид-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэмд байснаар хэвтэн эмчлүүлэгчийн тоо 653 хүн, амбулаториор үйлчлүүлэгчийн тоо 10,063 хүнээр буурсан. Жишээ нь хөл хориотой байсан 11,12 сард хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 11 сард 45 хувь, 12 сард 50 хувиар, амбулаторийн үйлчлүүлэгч 22 хувиар буурсан нь орлого 10 хувиар тасрах шалтгаан болжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 89 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,342.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 15,520.7 мянган төгрөгөөр, нормативит зардлыг 299,865.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 21,042.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 4,768.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 28,687.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан хөтөлбөрийн арга хэмжээ байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтын орлого байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 160 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, шилэн дансны цахим хуудсанд огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,405.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 23,621.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлж ажилласан байна. Аудитаар өгсөн 12,279.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,405.5	1	5,405.5	0	0	100
Албан шаардлага	2	23,621.0	2	23,621.0	0	0	100
Зөвлөмж	5	12,279.2	5	12,279.2	0	0	100
Нийт дүн	8	41,305.7	8	41,305.7	0	0	100

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,418.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 670.3 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 12,418.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 670.3 мянган төгрөгийн зөрчилд 2 нөхөн төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Албан томилолтын олговрыг илүү олгосон 28.0 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтад нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчдад нөхөн олговор олгох журмын 2.4-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцоож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэсэн заалттай нийцэхгүй, Эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх акт тогтоох

2. Гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн тогтмол бус үйл ажиллагааны буюу ажлын хөлснөөс ЭМНДШ суутган тооцоогүй 642.3 мянган төгрөгийн зөрчил нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого” гэсний 32.1.2 дахь заалтад “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон ажлын хөлс” заалт, Эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын хөлснөөс ЭМНДШ-ийг суутган, нөхөн төлөлтийн тайлан гаргаж, Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлэх

3. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. “Мэдээллийн үнэ зөв, бодитой иж бүрэн байх”, 4.1.3. “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх” заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой цахимаар ажилласан болон цаг хугацаа хязгаарлагдсан байдлаас шалтгаалан нормативт зардал буюу эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний зардал болон хөрөнгийн үлдэгдэлд биет тестийн горимыг хэрэгжүүлээгүй, дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Зардлын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны материал, эмийн зарцуулалт 11,747.7 мянган төгрөгөөр зөрүүтэй, бүртгэлээр тавих хяналт сул байна.

4.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бүртгэлээр тавих хяналт сул байх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, хоолны материал, эмийн зарцуулалтад эрх бүхий тушаалтан хяналтаа сайн тавьж байх

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.2. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй, хуулийн өөрчлөлт хийгдээгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Хууль зөрчигдөх эрсдэлтэй.

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Хууль эрх зүйн акт болон УСНББОУС-3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэсэн стандартыг мөрдөж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.17	Аудитын нэр: Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/52/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Арьсны өвчин судлалын үндэсний төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг зөрчсөн.	642.3	Нөхөн төлбөрийн акт	Захирал, нягтлан бодогч	Ц.Уранчимэг, Ш.Гантуяа
2	Албан томилолтын олговрыг илүү олгосон зөрчил илэрсэн.	28.0	Нөхөн төлбөрийн акт	Захирал, нягтлан бодогч	Ц.Уранчимэг, Ш.Гантуяа
3	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Ц.Уранчимэг, Ш.Гантуяа
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй, дүрэм журам зааварт нийцүүлэн өөрчлөлт хийгдээгүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ц.Уранчимэг, Ш.Гантуяа
5	Хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны материал, эмийн зарцуулалт зөрүүтэй, бүртгэлийн хяналт сул байна.	11,747.7	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ц.Уранчимэг, Ш.Гантуяа
ДҮН		12,418.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 18/A0170079

Улаанбаатар хот

СТ-2021/52/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2 ажилтанд албан томилолтын олговрыг 28,000.00 төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр" олгох журмын 2.4-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", Сангийн сайдын 2018 оны 301 тоот "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан томилолтын олговрыг илүү олгосон 28,000.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Д.ЛХАМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264231

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар\7.Docx

001090435



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 20/А0170079

Улаанбаатар хот

САР-2021/50/СТЯ-ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй 642,300.00 төгрөгийг 7 хүнд илүү олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон ажлын хөлс", 32.1.4 "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн тогтмол бус үйл ажиллагааны ажлын хөлснөөс ЭМНДШ суутган тооцоогүй 642,300.00 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх

2.Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Д.ЛХАМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Gazar\8.Docx

001090438



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 63/АО170079

Улаанбаатар хот

Сэтг. 2021/50/СТХ ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас 15 мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "Мэдээллийн үнэ зөв, бодитой иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.1. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Э.ЭНХБААТАР

ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Д.ЛХАМСҮРЭН

